

Манмин Мэдээ

№ 74 2019 оны 8 сарын 4

Дагалдах тэмдэгээр дамжуулагдах Есүс Христийн сайн мэдээ!

Араб Эмират, Египет дэх номлогч нарын семинар, эдгэрэл ивээлийн цуглаан



5-р сарын 9нөөс 16хүртэл Араб Эмират, Египет, Лебанонд Гил Тэ шиг пастор (Дежон Манмин чуулганы хариуцагч)-удирдсан номлогчдын семинар болон эдгэрэл ивээлийн цуглаан болж өнгөрлөө.

Мусульман шашинтай улс Пакистанд Христийн сайн мэдээ түгээгдэхэд том түлхэц болсон “2000 оны И Жей руг пасторийг урьсан Пакистаны нэгдсэн их цуглаан”-с хойш Пакистанд үргэлжлүүлэн авралын зар тараах үйлс эрчимжиж, Ойрхи Дорнодод үйлчилж буй пастор номлогч нарт ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчний үйлс эрч хүчтэй түгээгдсээр байна.

Эхний цуглаан нь 5-р сарын 9ны (Пү) Араб Эмиратад Шарижа Лайн зочид буудалд Шарижа номлогч нарын семинар эхлэсэн юм (Зураг 1, 2).

И Жей руг пасторын дэлхий дахинаа сайн мэдээ тараах үйлчлэлийн тухай “Эрх мэдэлт хүч” видео танилцуулга үзүүлсэний дараа Гил Тэ шиг пастор нь “Эрх мэдэлт хүчний нөлөө” (Үйлс 2:22) гэсэн сэдвээр “Бурхан өнөө үед ч агуу хүч чадал, тэмдэг гайхамшиг үйлсээр сайн мэдээ эрч хүчтэйгээр тунхаглаж байна. Энэ мэт гадаадын нэгдсэн их цуглаануудаар төдийгүй хэвлэл

мэдээлэлийн сувгаар дамжуулан дэлхий даяарх үй олон хүмүүсийг аврана гэдэг нь Бурханы үгийн дагуу ариун амьдралаар амьдарч мөн үй олон мацаг барилт ба залбирлаар л эрх мэдэлт хүч илрэн гардаг” гэж номлогч хүний хувьд байх ёстой чухал шинж чанаруудын тухай дамжуулсан юм. Оролцсон номлогч нарын хувьд энэхүү нандин сургаалиас их ухаарал ивээл авлаа гэлцэж байлаа.

10ний өдөр Башир Бахадур пасторын удирддаг Шарижа сууринд орших Пакистаны нөхөрлөл цуглаанд Эдгэрэл ивээлийн цуглаан (Үйлс 19:11-12) болсон юм. Гил Тэ шиг пастор “Гэрэл дотор үйлдэхэд ерөөл” (1 Иохан 1:5) сэдвээр сургаал заасны дараа И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуураар нийт оролцогчид руу ханлан залбирч өгсөн юм. Тэгтэл 3жил сайн сонсож чадахгүй байсан нэгэн итгэгч сонсдог болж, 6сарын турш толгой нь маш хүчтэй өвддөг байсан нэгэн итгэгчийн өвчин тэр дороо эдгэрч гэрчлэл хийсэн юм (Зураг 5, 6).

Энэ өдрийн үдээс хойш 4цагт Араб Эмиратын нийслэл Абу дабид нэгэн цуглаанд мөн эдгэрэл ивээлийн цуглаан болсон юм. Гил Тэ шиг пастор нь энэ цуглаанд мөн

адил сэдвээр сургаал заасны дараа залбирал хийж өгсөн юм (Зураг 3). Тэгээд 2сарын турш өвдгөө нугалж чадахгүй байсан итгэгч Ариун Сүнсний галыг аваад өвдгөө нугалдаг болж, гараа өргөж чадахгүй байсан итгэгч гараа чөлөөтэй өргөдөг байсан төдийгүй энэ мэт төрөл бүрийн өвчин хөндүүр арилсан зэргээ гэрчилэхээр итгэгч нар дараалан зогсож байлаа (Зураг 7, 8).

Түүний дараа уг цуглааны хариуцсан пастор “Өнөөдрийн уг сургаал маш ивээл байсан ба богино хугацаанд олон итгэгч нар эдгэрэл аван гэрчилж байгаа нь маш гайхамшигтай юм” гэж талархан үүнээс хойш дахин байнга ирж байхыг хүсч байлаа.

12ны өдөр үдээс өмнө Египет Эзэний залралт цуглаанд эдгэрэл ивээлийн цуглаан хийсэн ба Гил Тэ шиг пастор “Өнө эртнээс далдлагдсан нууц” (1 Коринт 2:6-9) гэсэн сэдвээр сургаал заасны дараа залбирал хийж өгөхөд олон итгэгч нар эдгэрлийн хүч нөлөө маш ихээр илрэн гарлаа (Зураг 4).

Марина эгч дүү 5жилийн турш бараг өдөр бүр шахуу толгойгоор нь маш хүчтэй өвддөг байсан, Ом Емад итгэгч 25жилийн турш өвдөж хий ханиалга өвчнөөсөө тус тус эдгэрч

баяр хөөртэйгөөр гэрчилцгээж байлаа (Зураг 9, 10). Үүнээс гадна савны үрэвсэл, мөрний өвчин, мөн үрэвсэлт өвчнүүдээсээ эдгэрч Бурхандаа алдрыг өргөлөө.

Энэ өдрийн үдээс хойш нь Гил Тэ шиг пастор Азиз Морган пасторын цуглаанд очиж сургаал зааж, гар алчуураар залбирч өгсөн юм. Ингэхэд Амара итгэгч нь төрөлхийн нэг бөөртэй нь улмаас бие нь маш сул дорой бөгөөд 13жилийн турш өвчтэй байсан бөгөөд Магди итгэгч мөн өвчнөөсөө эдгэрсэн тухай гэрчилж байна (Зураг 11, 12).

13ний өдөр Манмин фаундэшион номлогчдын семинар урд өдрийн болсон газар болж өнгөрсөн ба Гил Тэ шиг пастор нь “Эрх мэдэлт хүчний үйлчлэл” (Үйлс 2:22) гэсэн сэдвээр “Номлогч хүн өөрөө Бурханы үгийн лотор амьдрах нь маш чухал бөгөөл. Бурханыг хүндэтгэсэн амьдрал гэж юу болохыг ухаарч үйлдэх ёстой” гэж захиж байлаа.

Энэ удаагийн үйл ажиллагаа нь Лебанонд болж өнгөрсөн юм. 15ны (Лх) гаригт номлогч удирдагч нартай уулзан, Манмины үйлчлэлийн тухай танилцуулан, 16ны (Пү) гаригт нэгэн цуглааны урилгаар очин мэндчилэн Манмины үйлчлэлийн тухай танилцууллаа.

Хайр бол энэрэнгүй дөлгөөн юм

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм.
Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй.”
1 Коринт 13:4

И Жей руг тэргүүн пастор

Хичээлдээ сайн хүүхэд бол шалгалт өгсөний дараа алдсан алдаагаа мартахгүй нь тулд тусад нь шалгаж нягталдаг. Яагаад юун дээр алдсан болохыг нягталж, тэр асуултыг ойлгож дахин алдахгүй болгодог. Энэ нь өөрийн сул тааруухан байдлаа богино хугацаанд үр дүнтэй засахад хичээлээ бүрэн ойлгоход маш дөхөм болдог.

Сүнслэг хайрыг бий болгох ч мөн үүний адил юм. Бурханы үгийг сонсож, тэвчиж чадахгүй юм юу болохыг, дөлгөөн ба ачлалт сэтгэлээр өвөрлөж чадаагүй зүйл нь юу болохыг өөрийн сэтгэлээ эргэн харж, үг ба үйлдлээ ажиглан анхаарвал богино хугацаанд сүнслэг хайрыг бий болгох боломжтой.

Энэ удаад үзэх сүнслэг хайрыг нэгэн хэсэг бол ‘Хайр бол атаархдаггүй’ гэсэн байдаг. ‘Атаархал’ гэдэг нь зүрх сэтгэл дэх атаа хорсол нь хирээс хэтэрч бусад хүмүүст хорон үйлдэх хүртэлх үйлдлийг хэлдэг.

Атаархал байвал бусад хүмүүс амжилттай явах, хайрыг хүртэхэд сэтгэл нь тавгуйтдэг. Надаас илүү мэдлэг боловсролтой, хангалуун, эрх мэдэлтэй хүний харвал сэтгэл тавгуйрхаж өөртэй ижил нөхцөлд байдаг бусдын амьдрал дээшилж байгааг хараад атаархдаг. Бүр цаашлаад үзэн ядаж, түүний эд зүйлийг хүртэл булаах гэдэг.

Нэг талаар ‘Тэр хүн хүлээн зөвшөөрөгдөж, мөн хайрыг авч байхад би юу болох вэ? Яагаад би дандаа ийм байх гэж?’ тавгуйтэн санаагаар унадаг. Бусадтай өөрийгөө харьцуулан сэтгэлээ тавгуйтүүлэн шархалдаг гэсэн үг юм.

Ихэнх хүмүүс санаагаар унаж байгаагаа атаархаж хорссондоо ч биш гэж амархан ярьдаг. Гэтэл сүнслэг хайр байгаа бол бусад хүн амжилт олвол санаагаар уналгүй харин ч хамтдаа баярладаг. Санаагаар унах юм уу өөрийгөө буруутгаж, баярлаж чадахгүй байна гэдэг нь бусдаас илүү хайрлагдаж, хүлээн зөвшөөрүүлэх Би нь амьд үлдсэн учраас юм.

Ийм атаа хорсол нь хурцадвал хорон муу үг үйлдлээр гарахыг атаархах үйлс юм. Тэгвэл үүний талаар хэд хэдэн талаас авч үзэцгээе.

1. Эр эм ба хайр дурлалын асуудлаас үүдэлтэй атаархал

Итгэлийн өвөг болсон Абрахамын ач хүү, Исаакын хүүд Иаковт Леа ба Рахел гэсэн хоёр эхнэр байлаа. Эд нар бол түүний нагац ахын охид бөгөөд төрсөн эгч дүүс юм.

Эгч болох Леа нь Иаковын нагац ахдаа хууртаж хүсэж авсан эхнэр нь биш бөгөөд дүү нь болох

Рахелийн Төлөө 14жилийн турш нагац ахдаа зарагдаж байж авсан эхнэр тул Иаков мэдээж Рахелдаа маш их хайрладаг байв.

Гэтэл эгч Леа нь түүнд 4хүү төрүүлж өгсөн ба Рахел тэр хооронд хүүхэд төрүүлж чадахгүй байсан тул эгчдээ маш их атаархаж нөхрөө зовоодог байлаа (Эхлэл 30:1). Үүний дараа ч Рахел ба Леа ч өөрсдийн шивэгчнээ өөрийн нөхөртөө татвар эм болгон өгөх хүртэл нөхөр Иаковынхаа хайрыг авах гэж тэрсэлддэг байлаа.

Хэрэв тэдний сэтгэл жоохон ч гэсэн сүнслэг хайр байсан бол эгч нь дүүгээ дүү нь эгчийгээ нөхрийнхөө хайрыг авч байгаад баярлах ёстой юм. Эцэстээ тэдний энэ атаархал нь Рахел, Леа, Иаков нарыг бүгдийг нь зовоож, бүр цаашлаад тэдний хүүхдүүдэд хүртэл муу нөлөө үзүүлдэг.

2. Бусад хүн надаас илүү дээр учир атаархах тохиолдол

Хүн болгоны чухалчлан үздэг үнэт зүйл өөр өөр тул атаа хөдлөх, мэдрэх байдал ч өөр юм. Гэвч ерөнхий байдлаар бусдын элбэг хангалуун байдал, мэдлэг боловсрол, гадна төрх, эрх мэдэл, хүч нөлөө зэргээр илүү байх юмуу илүү ихээр хайрлагдах үед атаа хөдөлдөг. Үүнийг гэр бүл, ажлын талбар, сургууль зэрэг газруудаас амархан олж харах боломжтой юм.

Жишээ нь ажил дээр албан тушаал ахих гэж өрсөлдөгч хүнийхээ дутагдалтай талыг илчлэх, байгуулагынхаа удирдлагад хэлж муулдаг. Сурагч хүүхдүүд бол хичээлдээ сайн хүүхдийг гадуурах юм уу багш нарын магтдаг сайн хүүхдийг дээрлэх явдал ч байдаг. Гэр бүлийн хүрээнд бол аав ээжийн хайрыг илүү авах гэж, илүү их хөрөнгө өвлөж авах гэх мэт ах дүүсийн хоорондох маргаан байдаг.

Эхлэл номын 4-р бүлэгт гардаг хүн төрөлхтөний анхны аллага хийсэн Кайн ч мөн адил юм. Бурхан дүү болох Абелийн тахилыг л хүлээн авсанаар гал шиг дүрэлзсэн атаа хорслоо дийлж чадаагүйн улмаас дүү Абелаа алсан юм.

Кайны хувьд тэрээр аав Адам болон ээж Евагаар дамжуулан Бурханы хүслийн дагуу мал амьтнаар цуст тахил өргөх ёстой талаар үргэлж сонсож сурсан ч дуулгавартай дагаж чадаагүй юм. Эсрэгээрээ Абел нь Бурханы хүслийн дагуу дуулгавартай дагаж хонин сүргийн анхны төл болох хурганы цусаар тахил өргөсөн учраас Бурхан түүний тахилыг л хүлээн авсан байдаг. Тэгсэн ч Кайн өөрийн бурууг хүлээн авах нь байтугай дүүдээ атаархаж эцэстээ түүний аминд

хүрдэг.

3. Итгэлийн ах дүүсийн хооронд атаархах явдал

Дэг журам, байр суурь, мөнтүүнчлэн итгэлээр манлайлж, итгэмжтэй үйлчилж байгаа ах эгчдээ атаархаж хүмүүс байдаг. Ердийн үед өөртэйгөө нас болон байр сууриар ойролцоо юмуу сайн мэддэг хүмүүсийн дунд элбэг тохиолддог. Бусад ямар нэгэн хохирол учруулсан зүйл байхгүй ч бухимдан сэтгэл тавгуйтдэг. Бие биенээ сайн мэддэг тул өөрөөс нь хол ялгаагүй, олон дутагдалтай гэж санагддаг мөртлөө хайрлагдаж, хүлээн зөвшөөрөгдөхөд нь сэтгэл гонсойж тавгуйрхдэг.

Хэрэв атаархал төрүүлсэн хүн нь өөрийнх нь үйлчлэх ёстой байр сууриар өндөр удирдах хүн бол түүний үгийн дагуу дагая гэх сэтгэлгүй харин ч эсрэгээрээ удирдах хүнийхээ алдаа дутагдлыг бусдад дамжуулж ямар нэгэн аргаар унагаах гэдэг. Мөн надаас нас болон туршлагаар бага байр сууриар дорд хүн манлайлж эхлэвэл атаа жөгөө хүчтэй мэдрэгдэнэ.

Израйлийн анхны хаан Саулд Давид улс орныг аварч өгсөн ачтан юм. Гэтэл дайн тулаанаас их ялалт байгуулан буцаж ирэхдээ Саул ба Давидыг уухайлан угтаж буй ард түмний (1 Самуел 18:7) үгээс болж Саулын атаа хөдөлж, давидыг эцсээ хүртэл амийг нь хороох гэж зүтгэж байсан юм. Эцэст нь Филистийн дайнд өөрийн амиа хорлох хүртлээ ийм атаархлын улмаас нэг мөч ч тайван байж чадаагүй юм.

Тооллого номын 16-р бүлэг үзвэл Леви овгийн Кора ба Реубен овгийн Датан болон Абирам гэх ах дүүс Мосе болон түүнд тусладаг Ааронд сэтгэл тавгуйтэн өс санадаг. Тэд өөрсдийг нь дарангуйлж байна гэж бодон, түүнчлэн бас өөрсдөө ч удирдагч болох гэсэн нууцхан хүсэлтэй байсан юм. Тэгээд хүмүүсийг далдуур цуглуулан 250гаруй дэмжигчидтэй болсоны дараа өглөө удирдлагыг авах гэсэн санаатай байлаа. Тэд өөрсдийгөө хангалттай ялах болно гэж бодсон тэд шууд Мосе болон Аарон нар дээр очиж сөргөлдсөн юм (Тооллого 16:3).

Мосетой тэд нүүр тулан түүнийг элдвээр хэлэн шүүмжлэхэд тэрээр юу ч хэлээгүй юм. Зөвхөн Бурханы өмнө сөгдөн залбирсаны дараа тэдний алдааг ухааруулж өгч, Бурхан энэ явдлыг шүүж өгөхийг гуйсан юм. Тэгтэл Бурханы уур хилэн бууж, газар хуваагдан, тэд гэр бүл, Корад хамаарах бүх хүн нь эд агуурстайгаа унаж, тэднийг дэмжсэн 250хүн галаар устгагдсан юм.

Бурхан Мосед атаархсан тэдний гэм хичнээн том


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

болохыг бүх ард түмэнд үзүүлж ухааруулж өгсөн юм. Бурханы босгож өгсөн хүнийг дүгнэж шүүх нь Бурханыг буруутгаж байгаатай адил учраас юм.

4. Хоосон зүйлсийн төлөө атаархах нь мунхаглал юм

Иаков номын 4:2д “Та нар шунан хүсдэг бөгөөд та нарт байхгүй болохоор нь хүн алдаг. Та нар атаархдаг бөгөөд олж авч чаддаггүй. Тиймээс та нар тэмцэлдэж, хэрэлддэг...” гэсэн байдаг.

Бид атаархлаа гээд хүссэн болгоноо өөрийн болгоно гэсэн үг биш юм. Тодорхой хэмжээнд бусад руу дайралт хийж хүнд байдалд оруулж, өөрөө ялж байгаа мэт харагдах ч яг л бумеранг шиг өөрийнх нь хорон үйлдэл буцаж өөрт нь ирдэг юм. Өөрийнх нь хорон үйлдлийн улмаас өвчин тусах юм уу гэр бүл ажлын талбар нь гай зовлонд унадаг.

Атаархал нь өөрөө өөрийгөө л гэмтээх тул ямар ч ашиг үр нөлөө байхгүй хоосон зүйл юм. Түүнчлэн бусдаас илүү гарахыг хүсч атаархаж хорсохын оронд үхэл амьдралыг жолоодогч Бурханаас гуйх хэрэгтэй юм. Дийлэнх хүмүүс зөвхөн өөрийн тав тух, нэр төрийн төлөө эд баялаг, эрх мэдэл, нэр алдрыг л гуйдаг ч түүнээс илүү чухал зүйл бол өөрийнх зүрх сэтгэлийн өөрчлөлт юм.

Хичнээн олон зүйлийг эдэлж, эзэмшдэг байлаа гээд сүнс сэтгэл нь аврагдаж чадахгүй бол ямар ашигтай вэ? Бидний үргэлж санаж байх зүйл бол энэ ертөнцийн бүх зүйл хоосон болохыг мөн эцэстээ уур манан мэт сарнин алга болдог нь үнэн юм (Номлогчийн үгс 12:8).

5. Атаархал ба сүнс талын шунал гэдэг ондоо

Бурханд итгэдэг гэсэн мөртөлөө атаархдаг шалтгаан нь итгэл багатай хайр байхгүй учраас юм. Бурхан ба тэнгэрийн орны тухай итгэл сул тул мөн хайр бага учир ертөнцийн нэр алдар эрх мэдэл, зэргийг олохын төлөө атаархах тохиолдол бий.

Аврал хүртсэн Бурханы хүүхдийн хувьд тэнгэрийн орны иргэний харьяалал байгаа гэдэгтээ бат итгэл байгаа бол Эзэн дотор нөхөрлөж буй итгэлийн ах эгч дүүстэйгээ ч мөнхөд хамт амьдрах болно гэдэгтээ итгэдэг. Хэдийгээр хараахан Эзэнд итгээгүй хүнийг ч гэсэн аврал хөтлөх эрхэм хүмүүс нь өөрөө төгс үлгэрлэж чаддаг юм.

Эндээс жинхэнэ хайр бууж ирэх тусам хөршөө өөрийн бие адил хайрладаг болох тул бусад хүн амжилттай явбал би өөрөө амжилтанд хүрсэн мэт аз жаргалтай болох юм.

Жинхэнэ итгэлтэй хүн бол ертөнцийн хоосон зүйлийн хойноос хөөцөлддөггүй юм. Ямар ч байсан

илүү сайхан тэнгэрийн орон руу орохын тулд Эзэний ажлыг илүү идэвхитэй, итгэмжтэйгээр хийдэг. Өөрөөр хэлбэл сүнслэг шунал гэж хэлж болох юм (Матай 11:12). Сүнслэг шунал нь мэдээж атаархалаас тэс ондоо зүйл юм.

Эзэн дотор мэдээж хэнээс ч илүү хичээнгүйлэн өөрчлөгдөн, халуун сэтгэлээр зүтгэх сэтгэл чухал ч гэсэн түүнээсээ хэтрүүлэн үнэнээс холдон бусдыг бүдрүүлэх явдал байж болохгүй юм. Үргэлж эргэн тойрноо ажиглан, өөрийн эрх ашгаас илүү бусдын эрх ашгийг хайж, эвтэй байдал дотор сүнслэг хайрыг бий болгох хэрэгтэй юм.

Хайрт итгэгч та бүхэн, 1 Иохан 2:17д “Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал нь өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлддэг нэгэн нь мөнхөд оршдог” гэсэн байдаг. Тэгтэл атаархал бол хорон муу, бохир сэтгэлийн шинж чанар ба гадна талаараа илрэн гардаг тул атаархдаг хүн аврал авах нь хэцүү байдаг (Галаг 5:19-21). Энэ нь нүдэнд ил харагддаг гэм учраас тэр юм.

Түүнчлэн ертөнцийн хоосон зүйлд зууралддаг учир ах дүүсээ үзэн ядан атаархаж, муудалцах бус Бурханы өмнө зохистойгоор хайрлах сэтгэлтэй болж, мөнхийн тэнгэрийн оронд эзлэн орж, зүрх сэтгэлийн хүсэлд хүртэл хариулт авахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.



Улаанбаатар Манмин цуглаанд болсон “Эдгэрэл ивээлийн цуглаан”

5-р сарын 17ны (Ба) орой 7цагаас Анхбаяр ахлагч уг цуглааныг хөтлөн явуулсан бөгөөд Улаанбаатар Манмин цуглааны урлагын багийн бялхам дүүрэн тоглолт ба төв сүмээс ирсэн “Тэрлийн дуу” багийн монгол хэл дээр Ариун Сүнсний тэсрэлт бүхий магтаал ба бүжгээр уг цуглаанд оролцогчдод агуу ивээл сэтгэл хөдлөм байдлыг улам нэмж байлаа.

Уг цуглааны номлогч И Ми ён пастор “Тэрэл дотор үйлдэхэд ерөөл” гэсэн сэдвээр сургаал заасны дараа гэмшлийн болон Ариун Сүнсээр дүүрэх залбирлыг удирдан, үргэлжлүүлэн гар алчуураар залбирал өгсөн юм. Залбирал ба мацаг барилтаар бэлдсэн итгэгч нар Ариун Сүнсний гал буух хүчийг мэдэрч өвчнөөсөө эдгэрч Бурхандаа алдрыг өргөсөн юм.

Наранцэцэг (65нас, эм) итгэгч нь өвдөг, үе мөчнийөвчн хөндүүрээр сайн алхаж чадахгүй байсан бол сайн алхдаг болж, Хандаа (28нас, эм) итгэгч толгой эргэх нь эдгэрч, Буяндэлгэр (24нас, эр) итгэгч нурууны диск өвчнөөсөө эдгэрэх зэрэг маш олон итгэгч нар өвнөөсөө

эдгэрч баяр хөөртэйгөөр гэрчилцгээж байлаа (4-р нүүрэнд).

Ялангуяа Сувдэрдэнэ (25нас, эм) итгэгч авто ослын дараах хүндрэлийн улмаас байн байн ухаан алддаг заримдаа 2-3цаг болж сэрдэг байсан ба энэ өдөр ухаан алдаад 5минут ч бололгүй залбирал авмагцаа сэргэж, хамтдаа баярлан Бурхандаа алдрыг өргөсөн юм.

18ны (Бя) үдээс хойш 2цагт Монгол Манмин цуглаанд Улаанбаатар болон Монгол Манмин цуглааны ажилтаны сургалт үргэлжлүүлэн 3:45с итгэгч нарын уулзалт мөн айл эргэлт болсон юм.



Монгол Манмин цуглааны 16жилийн ойн мөргөл болон баярын үйл ажиллагаа

5-р сарын 19ны Эзэний өдөр бага үдийн 10:30минут, Гранд Хилл зочид буудлын хурлын танхимд Батзориг ахлагчийн хөтлөлөөр уг үйл ажиллагаа явагдсан юм.

Улаанбаатар болон Монгол Манмин цуглааны урлагын багийнхан онцгой тоглолт ба Төв сүмийн “Тэрлийн дуу” багийн тоглолт нь цуглааны 16жилийн ойн баярын үйл ажиллагаанд баяр хөөрийг улам нэмж, номлогч И Ми ён пастор “Тосоо сайн бэлдэцгээ” гэсэн сургаалийг айлдсан юм.

Үдээс хойш 2:30 минутаас эдгэрэл ивээлийн цуглаан эхлэсэн бөгөөд номлогч И Ми ён пастор “Итгэл” гэсэн сэдвээр сургаал заасны дараа залбиралын цуглаан хийсэн юм. Үүнд

Туяа (57нас, эм) туслагч өмнө огт сонсдоггүй байсан баруун чих сонсдог болж Баяр (76нас, эр)итгэгч зүрхний мэс засал орсон бөгөөд түүний хожуу хүндрэл улмаас нугалж атгаж чадахгүй байсан гар хэвийн болсон.

Өлзий учрал (73нас, эм) итгэгч огт харж чаддаггүй баруун нүдэндээ залбирал авсаны дараа гэрэл мэдрэн хардаг болсон ба одоо бүр хэлбэр дүрс харагддаг болж бага багаар хараа сайжирч байгаа.

Энэ өдөр ч шинэ итгэгч нар маш ихээр цуглан, 7жилийн турш өвдсөн өвдөгний үе мөчний үрэвсэлт өвчин, 20жилийн турш архаг ревматизм өвчин, бөөрний өвчин зэрэг өвчнүүдээсээ эдгэрэл авч Ариун Сүнсний хүч нөлөөг гэрчлэн Бурханд алдрыг өргөсөн юм.





“Сондоггүй байсан чих сондог болж, сэтгэлд баяр хөөрөөр дүүрэн байна”

Баярсайхан итгэгч (42нас, Монгол Манмин цуглаан)

5-р сард Эдгэрэл ивээлийн цуглаан болно тэнд оролцоод залбирал авбал Бурхан эдгээж өгөх болно гэсэн мэдээ би сонссон юм. Би өвчнөөсөө заавал эдгэрэхийн тулд Монгол манмин цуглаанд бүртгүүлсэн юм.

Хорин настайгаас эхлээд тоосонцор ихтэй хувцасны үйлдвэрт ажилдаг тул баруун нүднээс байн байн нулимс гарч, эмийн буруу хэрэглэснээс болж баруун чих сонсохгүй болсон юм. Тэгж байгаад саяхан 2жилийн өмнө ээж маань өөд болоход уйтгар гунигт автаж үргэлж уйлдаг байлаа. Тэгээд л хүмүүсээс хол хөндий байж, ихэнхдээ гэртээ л байдаг байлаа.

5-р сарын 17ны өдөр Улаанбаатар Манмин цуглааны эдгэрэл ивээлийн цуглаанд суусан юм. Номлогч И Ми ён пастор нь И Жей руг пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12) аар залбирал хийж өгөхөд надад гайхамшигтай зүйл тохиолдов. Бүх биеэр халуу дүүгж огт сондоггүй байсан баруун чих бага зэрэг сонсож эхэлсэн юм. Дараа өдөр нь И Ми ён пастортой уулзах уулзалтын үед илүү сайн сондог болсон юм. Мөн баруун нүднээс байнга нулимс гоождог байдал ч арилсан юм.

“Эзэний ивээлээр төрөлтийн дараах хам шинж, ганихрах, бүр илүүдэл жин хүртэл бүгдийг шийдсэн юм”

У Хи жон туслагч (44нас, 3-р бүлэг 31-р хэсэг)

2008онд гуравдах хүүхдээ төрүүлсэний дараа гам сайн барьж улмаас бие маань зовиурлаж байв. Бүх биеэр сэрүү татаж, хүйтэн хөлс гарч их зовиуртай байлаа. Тэгээд 2010оны зун дөрөвдэх хүүхдээ гаргахад бие маань дээрдэхгүй төрсний дараах хам шинж хүндэрч, 4улиралын турш үргэлж даарч, өвөл нь зузаан малгай өмсч, халаасны дулаацуулагч заавал авч явдаг байсан юм.

Ингэж бие минь суларснаар ажил тараад гэртээ ирэхэд шууд хэвтэх, эсвэл багахан стрессдэхэд л идээд хэвтдэг зуршилтай болсноор биеийн жин нэмэгдсээр байлаа. 2012оны цуглаанд ирэн төрсний дараах хам шинж маш их сайжирсан ч бүрэн эдгэрч чадалгүй байдлаар цаг хугацаа өнгөрсөөр л байлаа.

2017оны шинэ оныг угтан ямар нэгэн байдлаар итгэлийн амьдралдаа шинэ эргэлт хиймээр санагдсан юм. Тэгээд Залбирлын хорооны онцгой эдгэрэл ивээлийн цуглаанд оролцсон ба И Буг ним ахлагч надад биеийн байдлын төлөө мөн илүүдэл жингээ хасахын тулд 7хоног төлөвлөсөн залбирал хий гэж зөвлөсөн юм. Гэсэн ч би төлөвлөсөн зүйлдээ хүрч чадалгүй дахин 5кг жин нэмж өндөр 158см хэдий ч биеийн жин 75кг давж байлаа.

Тэгж байтал 2018оны хавар ажил дээр хүнд байдалд орсон юм. Би бага сургуулийн тусгай боловсролын багшаар ажилдаг бөгөөд миний буруутай үйлдлийн тухай тайлбарлаж байх явцад буруу ойлголт тарж, зөвшилцөлд хүрч чадаагүй нь улмаас ажилдаа явж чадахгүй болсон юм. Тэгээд сэтгэл санааны хүнд дарамтад орсон улмаас маш хэцүү байсан бөгөөд энэ ганихрах өвчний эхлэл байсан юм.

Буруу ойлгогдсондоо маш их гомдон бухимдаж, ичиж бүх үйл явц хэцүү буруу

тийш эргэж байгаад зүрх салгалж чичрэн маш тайван бус, таагүй байдалд байсан юм. Эмнэлэгт очоод үзүүлтэл “Ганихрах хам шинж дунд шат”, “Архаг стресс” гэсэн оноштой болсон юм. Тэр л үеэс би Бурхан Аавыг хайж эхлэсэн юм.

Дахин Манмин залбирлын хорооны эдгэрэл ивээлийн цуглаанд сууж, сургаал сонсож, өөрийн зөв үзэл баримтлал, бардам байдал, бусдыг ойлгож чадаагүй сэтгэлээ эргэн харж, Бурханы сургаалиар өөрийн зохисгүй өнгөрсөн дүр төрхөө санаж, нулимсаараа гэмшиж шийдвэр гаргахад ивээл их авсан юм. Тэндээс урьд төлөвлөөд сахиж чадаагүй 7хоногийн Даниел залбирлаа сайн дуусгаж чадсан юм.

Энэ мэт сүнс талын бялхам байдлаа сэргээхэд нэг л мэдэхэд биеийн ядаргааг ялан дийлдэг болсон байв. Хоолны дуршилаа ч тохируулж чаддаг болсон юм. Өдөр нь залбирлын цуглааны өдрийн залбирал сууж, орой нь Даниел залбиралдаа суух тул ердийн үеэс унтах цаг багассан ч өмнөх шиг бие хөндүүрлэхгүй болсон байв. Залбирлын цуглаанд 8н сар яваад 17кг хаяж чадсан юм.

Ялангуяа хамгийн гайхалтай нь 2018оны өвөл даарах жихүүцэхийг төдийлөн мэдрэхгүй өнгөрч, халаасны халаагч ганц ч удаа хэрэглээгүй юм. Сургаал ба залбирлаар ганихрах, стресс хам шинж цэвэрхэн эдгэрч 2019он 3-р сард дахин ажилдаа орж, аз жаргалтай амьдарч байна. Халлелүяа!

Сүнс сэтгэл сайжрах тусам бүх зүйлийг удирдаж сүнс махан талыг бүгдийг эдгээж өгсөн хайрын Бурхан Аавдаа бүх талархал ба алдрыг өргөн, намайг аварч өгсөн Эзэндээ талархалыг өргөө. Түүнчлэн амийн сургаалиар ерөөлийн замаар удирдаж буй тэргүүн пастордаа баярлалаа.



Зөвхөн энэ төдийгүй залбирал авч байхад гэнэт гар минь салгалж би өөрийн мэдээгүй ухаан алдсан бөгөөд надаас муу сүнс зайлж байгаа нь мэдрэгдсэн юм. Түүний дараа хүн эгцэлж хардаг болсон бие чичрэх нь ч алга болсон юм. Халлелүяа!

Одоо миний бие маш сайжирч сайн сондог болсон ба сэтгэл санаа маш тайван байна. Чөлөөтэй гадуур гарч, хүмүүстэй ярилцаж цагыг аз жаргалтай өнгөрөөдөг болсон. Там мэт амьдрал минь тэнгэрийн орон мэт солигдсон юм.

Энэ мэт би өвчнөөсөө эдгэрч манай нөхөр ч залбирал аваад зүүн нүдний хараа сайжирахад би “Үнэхээр Бурхан амьд оршдог байхнээ, тэнгэрт жинхэнэ Бурхан байдаг” гэж бат итгэлтэй болсон юм. Одоо манай гэр бүл Эзэний хайраар аз жаргалтай байна. Надтай уулзаж өгсөн сайн Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин